

ЭМГЭНЭЛ



Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрэлээнгийн Хятад судлалын салбарын эрхлэгч Лашидын Бэгзжав 2012 оны есдүгээр сарын 16-ны өдөр өвчний улмаас таалал төгсч ертөнцийн мөнх бусыг үзүүлээ.

Лашидын Бэгзжав Говь-Алтай аймгийн Тайшир сумын уугуул, 1979 онд МУИС-ийн Хятад судлаач, хятад хэлний орчуулагч мэргэжлээр, 1992 онд

Бээжингийн Хэл соёлын их сургуулийн дээд курс төгссөн. 1979 оноос одоог хүртэл ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, сэтгүүлийн эрхлэгч, ахлах ажилтан, 1981-1982 онд БНХАУ-д суугаа Монгол улсын ЭСЯ болон Монгол-Хятадын хилийг хамтран шалгах комисст орчуулагчаар ажиллаж, 1987, 1990 онд ЗХУ-ын Алс Дорнодын институтэд 2 удаа, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Зүүн хойт Ази судлалын хүрээлэн, Шаньдуны их сургууль зэрэг газарт 6 удаа мэргэжил дээшлүүлж, томилолтоор ажилласан. 1990-1991 онд Бээжингийн их сургуулийн Олон улсын харилцааны сургуульд зочин профессороор ажиллажээ.

Тэрээр хятад судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний ном товхимол 4, хамтын бүтээл 16, сурах бичиг 1, хятад орос хэлнээс орчуулгын ном 4, эрдэм шинжилгээний өгүүлэл 35, лекц 8, судалгаа сурталчилгааны өгүүлэл 350 гаруйг бичиж, орчуулгын өгүүлэл 100 гаруйг нийтлүүлж, 16 ном, 60 гаруй сэтгүүл, 4 сонины 40 гаруй дугаар редакторлаж, нийтдээ 600 гаруй өгүүлэл орчуулга нийтлүүлжээ.

Л.Бэгзжав нь гадаад дотоодын эрдэм шинжилгээний хуралд 40 гаруй удаа илтгэл тавьсны дотор олон улсын хуралд 18 удаа төлөөлөгчөөр оролцжээ. Түүний бүтээлээс ЗХУ, БНСЧСУ, Болгар, Вьетнам, Шинэ Зеланд, АНУ, Япон зэрэг оронд орос, хятад, англи, япон, вьетнам, казак хэлээр олонтаа хэвлэгдэж, радио телевизээр

нэвтрүүлэгдсэн байна.

Л.Бэгзжав нь "Алтан гадас" одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Монголын радио, МОНЦАМЭ агентлаг, "Улаанбаатар сонин" зэрэг хэвлэл мэдээллийн шилдэг бичлэгийн оны шагнал хүртэж байв. Түүний ажлын үр бүтээлийг үнэлж "Тэргүүний сэхээтэн залуу", "ҮII таван жилийн залуу гавшгайч", алтан медаль, "Тэргүүний лектор" өргөмжлөл, "Шинжлэх ухааны тэргүүний ажилтан", "Ардын боловсролын тэргүүний ажилтан", "Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан" цол тэмдэг, "Багшийн алдар" медаль, ГХЯ, Хилийн цэргийн удирдах газар зэрэг байгууллагын хүндэт үнэмлэхээр шагнаж байлаа. Тэрээр "Монгол-Хятадын харилцаа (1949-1999)" сэдвээр түүхийн шинжлэх ухааны докторын (Ph.D) зэрэг хамгаалсан, 2001 онд дэд профессор, 2008 онд професwсор цол хүртсэн.

Л.Бэгзжав нь Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн, Монголын Хятад судлаачдын холбооны ерөнхийлөгч, зэрэг олон нийтийн сонгуульт ажлыг 18 жил хийж гүйцэтгэжээ. Тэрээр ажиллахын зэрэгцээ 1979 оноос МУИС, Олон улсын харилцааны дээд сургууль, Боловсролын их сургууль, Улаанбаатар их сургууль, Түгээмэл дээд сургууль зэрэг сургуульд 30 шахам жил хятад судлал, хятад хэлний орчуулга зэрэг хичээлийг зааж ирсний дотор 2001 оноос "Түгээмэл", "Улаанбаатар-эрдэм судлал" дээд сургуулийн гадаад хэлний тэнхимийн эрхлэгч зэрэг ажлыг хавсран хийж байна.

Талийгаачийн мятаршгүй хөдөлмөрч, үнэнч шудрага, эгэл даруу, нийтэч, нөхөрсөг тусч зан чанар, гэгээн дүр төрх бидний зүрх сэтгэлд мөнхрөн үлдэх болно.

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

Огноо: 2012-09-17